

АГУУЛГА

Оршил	2
1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
1.1. Төслийн тухай товч танилцуулга	3
1.2. Төслийн зорилго	3
1.3. Төслийн байршил	3
1.4. Төслийн хүчин чадал	5
1.5. Хүдэр баяжуулах технологи	5
1.6. Хайлуур жоншны хүдэр баяжуулах үйлдвэрийн ажиллах горим	5
2. Төслийн талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт	7
2.1. Нийгэм эдийн засгийн төлөв байдал	7
2.2. Хүн ам зүйн	7
2.3. Хөдөө аж ахуй	7
2.4. Хөнгөн, хүнсний аж үйлдвэр	7
2.5. Байгаль орчин	8
2.5.1. Уур амьсгал	8
2.5.2. Агаарын чанар	8
2.5.3. Гадаргын ус	9
2.5.4. Газрын доорх ус	9
2.5.5. Хөрсөн бүрхэвч	9
2.5.6. Ургамлын орчны нөхцөл	10
3. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт	11
4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	12
5. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	16
6. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	18
7. ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	19
8. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	22
9. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	24
10. БОМТ-НИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ	24
11. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСВИЙН ЗАДАРГАА	25

ОРШИЛ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрх зүйн баримт бичиг юм.

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа Байгаль орчны тухай багц хуулиуд болон тэдгээртэй холбогдон гарсан дүрэм, журам, стандартууд, БОАЖЯ-ны 2021.06.21-ний өдрийн 13/2766 тоот байгаль орчны ерөнхий үнэлгээний дүгнэлт, 2023 онд “Баруун сухай” ХХК-ийн боловсруулсан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан болон БОАЖС-ын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалын Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын 3-р хэсэг болох тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгах агуулгад заасны дагуу боловсруулав.

Энэхүү төлөвлөгөөгөөр “Жонш баяжуулах үйлдвэр” төслийн үйл ажиллагаатай холбогдон бий болж болзошгүй сөрөг нөлөөллөөс тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны зорилтууд, нөлөөллийг бууруулахаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл, хуваарийг тогтоосон бөгөөд энэхүү 2026 оны БОМТ нь 2023 онд батлагдсан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн 4 дахь жилийн БОМТ юм.

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн тухай товч танилцуулга

Төслийн нэр: “Жонш баяжуулах үйлдвэр”

Төсөл хэрэгжүүлэгч байгууллага:

“Хэрлэн Импэкс” ХХК

ААН улсын бүртгэлийн дугаар:

9019073096

Регистерийн дугаар:

2009765

Хаяг:

Дорноговь аймгийн Айраг сум, 4-р баг,
Цагаан дөрвөлж, ТЗ-ын өртөө

Холбоо барих утас:

88003860

1.2. Төслийн зорилго


Дорноговь аймгийн Айраг суманд баригдан ажиллаж буй жоншны Баяжуулах үйлдвэр нь жилд 80.0 мян.тн хүдэр боловсруулах хүчин чадалтай, хагас автоматчилагдсан тоног төхөөрөмжтэй, технологийн процессийн хяналтын систем, эрдсийн болон орчны шинжилгээний лабораторитай үйлдвэр байна. Үйлдвэрийг ашиглалтанд оруулснаар нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх нөхцөл хангагдаж бүс нутгийн үйлдвэрлэл, нийгмийн хөгжилд ихээхэн түлхэц болно.

1.3. Төслийн байршил

Төслийн байршил нь Дорноговь аймгийн Айраг сумын нутагт “Өмнөд-Алтат”-ын жоншны ордын талбайд буюу байр зүйн зургийн L-49-75 хавтгай дээр Хайртын уурхайн зүүн талд оршиж байна.

Хүснэгт 1. Баяжуулах үйлдвэрийн солбилцол

№	Урттраг			Өргөрөг		
	град	мин	сек	град	мин	сек
1	109	23	56.73	45	45	26.62
2	109	23	9.28	45	45	26.62
3	109	23	9.28	45	45	36.62
4	109	23	53.73	45	45	36.62



Зураг 1. Төслийн талбайн байрзүйн зураг



Зураг 2. Баяжуулах үйлдвэрийн зохион байгуулалтын зураг/дрон/

1.4. Төслийн хүчин чадал

Баяжуулах үйлдвэр нь нэг давхар шаталсан хэлбэрээр баригдсан бөгөөд энэ нь бүтээгдэхүүн өөрийн урсгалаар процесст тээвэрлэгдэж, дотоод тээвэрлэлтийн төхөөрөмжийн хэрэглээг бууруулна гэж үзсэн байна. ТЭЗҮ-д тооцсоноор жоншны хүдэр баяжуулах үйлдвэрийн жилийн хүчин чадал нь 80.0 мян.тн байна.

1.5. Хүдэр баяжуулах технологи

Хайлуур жоншны хүдрийг флотацийн аргаар баяжуулах технологийг сонгохдоо захиалагчаас өгсөн техникийн даалгавар болон “Хэрлэн импекс” ХХК-ийн хайлуур жоншны баяжуулах үйлдвэрт хийсэн үйлдвэрийн сорьцлолтын ажлын шинжилгээний үр дүн, баяжуулах үйлдвэрийн ажилласан хугацаан дахь технологийн үзүүлэлтүүд зэрэгт тулгуурлан баяжуулах технологийг сонгон доор дурдсан технологийн ерөнхий шийдлүүдийг гаргасан.

Хүснэгт 2. Технологийн ерөнхий шийдлүүд

Бутлах цехийн хүчин чадал	80 мян.тн/жил 768 тн/хоног 48тн/цаг 227 хоног/жил 4687 цаг/жил
Нунтаглан баяжуулах цехийн хүчин чадал	150 мян.тн/жил 768 тн/хоног 32 тн/цаг 217 хоног/жил 3125 цаг/жил
Анхдагч хүдэр дэх жоншны агуулга	30-40%
Анхдагч хүдрийн нягт	2.62 гр/см ³
Хүдэр бэлтгэх процесс	3 шатны бутлалт 1 шатны шигшилт 1 шатны нунтаглалт 1 шатны ангилалт
Хүдэр баяжуулах технологи	Үндсэн флотаци 7 шатны цэвэрлэгээний флотаци 2 шатны хяналтын флотаци
Туслах хэсэг	Өтгөрүүлэх, шүүх, хатаах хэсэг Урвалж найруулах хэсэг Хаягдал хадгалах байгууламж

Флюоритын эрдсийг хоосон чулуулгаас салгаж, 97%-ийн агуулгатай баяжмал гаргахын тулд цуглуулагч урвалжаар тосны хүчил, дарагч урвалжаар шингэн шил, булингын орчин тохируулагчаар техникийн сод зэрэг химийн бодис урвалж ашиглах бөгөөд үүнд гурван шатны бутлалт, 2 шатны нунтаглалт хийж үндсэн, хяналтын, цэвэрлэгээний флотацийн цикл шат дамжлагуудыг хэрэглэн жоншны ФФ-97 маркийн баяжмал гаргаж авна.

1.6. Хайлуур жоншны хүдэр баяжуулах үйлдвэрийн ажиллах горим

Баяжуулах үйлдвэр нь жил бүр 3-р сарын 1-с 10-р сарын 31-ийг дуустал тасралтгүй ажиллагаатай байх ба өвлийн эрс хүйтний үед сул зогсолт хийн ажилчдаа

амрах бөгөөд Монгол Улсын хууль тогтоомжуудад заасны дагуу олон нийтээр амрах баяр ёслолын хоногууд, цаг агаараас саатах, ээлжит засвар үйлчилгээ, зэрэг хүчин зүйлүүдийг тооцон үйлдвэр нь 217 хоног ажиллана гэж төсөлд тусгалаа. Баяжуулах үйлдвэрийн бутлах цех жилд 227 хоног, 2 ээлж, хоногт 16 цагаар ажиллах бөгөөд төв корпус, шүүн хатаах цех, хаягдлын аж ахуйтай нь ижил горимоор жилд 227 хоног, 2 ээлжээр хоногт 16 цагаар ажиллана.

Баяжуулах үйлдвэрийн технологийн процесс нь тасралтгүй ажиллагаатай байх шаардлагатай ба үйлдвэрийн ажилчдын хөдөлмөр зохион байгуулалтыг төлөвлөхдөө хоногт 2 ээлж, ээлжийн үргэлжлэх хугацаа 8 цаг гэж төлөвлөсөн.

Хүснэгт 3. Баяжуулах үйлдвэрийн ажиллах хоног

1	Жилийн хуанли ердийн тоо	365
2	Жилийн хуанли сар	12
3	Жилийн хуанли цаг	8760
4	Өдрийн хуанли цаг	24
5	Баяжуулах үйлдвэрийн ажиллах горим	217
6	Төлөвлөгөөт засварын хоног	8
7	Урсгал засварын хоног	8
8	Баяр ёслолын хоног	26
9	Цаг агаарын саатал	28
10	Өвлийн амралтын сул зогсолтын хоног	150
11	Өдөрт ажиллах бодит цаг	16
12	Сард ажиллах бодит цаг	660
13	Жилд ажиллах бодит хоног	217
14	Жилд ажиллах бодит цаг	5208
15	Цаг ашиглалтын коэффициент, %	90
16	Цагийн хүчин чадал, тн/цаг	48
17	Хоногийн хүчин чадал, тн/хоног	768
18	Жилийн хүчин чадал, тн/жил	150000

2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ- ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1. Нийгэм эдийн засгийн төлөв байдал

Төслийн талбай нь Дорноговь аймгийн Айраг сумын нутагт байрлах ба тус бүс нь газрын гадаргын хувьд намхан толгод, хотгор хотос, цав толгод бүхий ухаа гүвээ ээлжлэн солигдох бөгөөд талбайн зүүн болон зүүн хойд хэсгээр ерөнхийдөө зүүн хойноос баруун урагшаа чиглэлтэй намхан уулс, дов толгодорхог гадаргуутай байхад талбайн өмнөд болон баруун өмнөд хэсгээр уулс хоорондын хотгор бүхий жижиг хөндий байна.

Айраг Өртөө Улаанбаатар Төмөр замын харъяа Айраг Өртөө Цагаандөрвөлж багт, 3-р хороонд байрладаг. 1953 онд төмөр зам тавигдаж ашиглалтанд орж, 1964 онд өртөө болон өргөжсөн. Доноговь аймгийн Айраг сум нь 744258 га газар нутагтай. Үүнээс: Хөдөө аж ахуй, бэлчээрийн 705557 га, тусгай хэрэгцээний газар 29012 га, , хот суурин бусад суурин газар 4131 га, усан сан бүхий 1044 га талбай эзэлдэг.

2.2. Хүн ам зүйн

Нард, Сайн ус, Нүдэн, Цагаандөрвөлж гэсэн 4 багийн нийт 1112 өрхөд 3590 хүн амтай. Хүн амын 98% халх үндэстэн амьдардаг. Баруун талаараа Дундговь аймгийн Өндөршил, зүүн хойд талаараа Хэнтий аймгийн Дархан сум, бусад талаараа өөрийн аймгийн Даланжаргалан, Иххэт, Алтанширээ, Сайхандулаан сумдтай хиллэдэг. Төслийн талбайн нийгэм эдийн засгийн байдал: Төслийн талбай орчимд нутгийн оршин суугчдын өвөлжөө, хаваржаа байх боловч тусгай зөвшөөрлийн талбайтай давхардсан айлын газар байхгүй.

2.3. Хөдөө аж ахуй

Сумын хэмжээгээр нийт 111232 толгой мал тоологдсоноос цэвэр үүлдэр, эрлийз, нутгийн шилмэл омгийн 15600 мянган толгой мал тоологдсон нь нийт малын 14 хувь байна. 282 малчин өрх, 262 малтай өрх байгаа нь сумын нийт өрхийн 49 хувийг эзэлж байна. Сумын хэмжээгээр жилд 1,5 га талбайд төмс, 1,72 га талбайд хүнсний ногоо тариалж 21,0 тонн төмс, 30,0 тонн хүнсний ногоо, хураан авсан байна.

Сумын хэмжээгээр нийт 111232 толгой мал тоологдсоноос адуу 6877, үхэр 2857, тэмээ 888, хонь 43109, ямаа 38197 байгаа бөгөөд цэвэр үүлдэр, эрлийз, нутгийн шилмэл омгийн 15600 толгой мал тоологдсон нь нийт малын 16,9 хувь байна. 253 малчин өрх, 347 малтай өрх байгаа нь сумын нийт өрхийн 54 хувийг эзэлж байна.

2.4. Хөнгөн, хүнсний аж үйлдвэр

Эрчим хүч, барилгын материалын аж үйлдвэр

Сумын төвд 2 төвлөрсөн уурын зуух ажиллаж дулааны хэрэгцээгээ хангаж байна. Сумын төв дээр 110/35/10кВт-ын цахилгаан дамжуулах Дэд станцтай. Блок үйлдвэрлэж, шар шавар өрлөг хийхэд ашигладаг.

1984 онд баригдсан. Цагаандөрвөлж 1 хороонд байрладаг 9 хүний оронтоотой ажилдаг. Цахилгаан эрчим хүч дамжуулах үйл ажиллагаа эрхэлдэг. Цахилгаан халаагууртай Жилд 65- 70 сая кВт/ цаг цахилгаан эрчим хүчийг дамжуулдаг. Суурьлагдсан хүчин чадал нь 12.6 мВт хүчин чадалтай.

Зам харилцаа

Сумын газар нутгаар ОХУ, БНХАУ - ыг холбосон олон улсын чанартай төмөр зам, мөн хатуу хучилттай авто зам дайран өнгөрдөг. Орон нутгийн иргэд, ААНБ - ууд суудлын болон ачааны 500 орчим авто машин байнгын хөдөлгөөнд оролцож байдаг. Босоо тэнхлэгийн замаас салаалсан сумын төвд 1,7 км урттай хатуу хучилттай замтай. Багууд хоорондоо шороон замаар холбогддог. Монгол Оросын хувь нийлүүлсэн Төмөр замын зангилаа байрлаж нийт 110 гаруй ажилтантай 9н анги, салбар нэгжүүд үйл ажиллагаа явуулж байна.

2.5. Байгаль орчин

2.5.1. Уур амьсгал

Тус төсөл хэрэгжих газар нутаг нь Монгол улсын бусад газар нутгийн адил эх газрын эрс тэс уур амьсгалын бүсэд байрлана. Төсөл хэрэгжих талбай орчмын нутаг дэвсгэрийн агаарын жилийн дундаж температур 3.5 – 3.7°C байна. Жилийн хамгийн дулаан 7-р сарын дундаж агаарын температур 23.1 – 24°C юм. Тус нутгаар 36.3 – 40.2°C-ийн үнэмлэхүй хамгийн их температур 5 %-ийн хангамжтай буюу 20 жилд 1 удаа тохиолдоно. Жилийн хамгийн хүйтэн 1-р сарын агаарын дундаж температур – 15.3°C байна. Үнэмлэхүй хамгийн бага температур –41.4 – 41.5°C хүйтэрсэн байна. Төсөл хэрэгжих талбай орчмоор анхны цочир хүйтрэлт 9-р сарын 17-ны үед эхлэн, 5-р сарын 23-ны үед дуусна. Монгол орны хувьд агаарын температурын жилийн дундаж сүүлийн 30 орчим жил 1.9°C-аар дулаарсан бол өмнө ба зүүн бүсэд 1.5-1.6°C, баруун ба төвийн бүсэд 2.0 - 2.3°C-аар тус тус дулаарчээ. Дулааралт хүйтний улиралд илүү их ажиглагдаж байгаа бөгөөд өвлийн улиралд агаарын температурын дундаж 3.6°C, хавар намрын улиралд 1.4-1.9°C-аар нэмэгдсэн байна.

2.5.2. Агаарын чанар

Жонш баяжуулах үйлдвэр байрлаж буй Айраг сумын 4 дугаар багийн нутагт орших бөгөөд хөдөө тал нутгийн агаарын бохирдолгүй, дуу чимээгүй, нунтаг ширхэглэлтэй тоосгүй хэсэг юм. Баяжуулах үйлвэрийн хаягдлын далан, усан сан, хаягдлын шаламаас үүсэх нарийн ширхэгт цагаан тоос үүсэх магадал их байна. Мөн

хуурайшилт ихтэй хавар, намрын улиралд агаарт дэгдэх тоосны хэмжээ харьцангуй ихсэх шинж чанартай байдаг.

2.5.3. Гадаргын ус

Судалгааны талбай түүний дүүрэг нь усан хангамж сайтай, ус зүйн үүднээс Номхон далайн ай сав, Умард говийн гүвээт-Халхын говийн сав газарт тус тус багтана. Цөөн тооны булаг нь гадаргад хагарлын бүсээр хянагдсан булгуудаар тэжээгдэх бөгөөд зуны улиралд буух хур тунадасны хэмжээтэй шууд холбоотой. Ихэнх хур тунадас 7-8-р сард бороо хэлбэрээр орно. Түр зуурын урсац бүхий цөөн тооны гол дулааны улиралд хур багатай жил шургаж усгүй сайрууд болдог. Судалгааны талбай орчимд байнгын устай гадаргын ус байхгүй. Районы хэмжээнд хур тунадасаар тэжээгддэг хужир, мараалаг, давсархаг шал тойрмууд цөөн тоогоор бий.

Газар нутгийн нийт чийгшил 250 мм -ээс дээш, усны гадаргаас уурших ууршилт 400-600 мм бөгөөд гол мөрний усны горим нь хаврын шар ус, зуны хурын усаар тэжээгддэг ба үүнээс газар доорхи усаар 20%, цасны усаар 25%, хурын усаар 55% тэжээгдэнэ. Голын хатуу урсацын жилийн хэмжээ 1-2 тн/км, голын усны булингаршил нь 100-200 г/м3 байна. Борооны үерийн хамгийн их урсацын модуль нь 0.2-0.4 км2 л/с байгаа нь дунд зэргийн үзүүлэлт юм.

2.5.4. Газрын доорх ус

Судалгааны талбайн газрын доорх усны онцлогийн талаар бичихдээ “Дунар-Од” ХХК- ийн 2010-2012 онд гүйцэтгэсэн “ӨМ-Дорнодын хэсэг орчмын гидрогеологийн 1:200000- ны зураглалын ажил зэрэг бусад материалаас үзэхэд төслийн талбай нь геологийн нийлмэл тогтоцтой, янз бүрийн нас, найрлагын гүний биетүүдээр зүсэгдсэн, хагарлын системүүдээр хэрчигдсэн блоклог бүтцийг бий болгосон байна. Мөн түүнчлэн физик газарзүйн нөхцлийн гол онцлог нь эрс тэс эх газрын уур амьсгалтай, унах хур тунадасны хэмжээ бага, ууршилт нь хур тунадаснаасаа давдаг, байнгын урсацтай гадаргын ус байхгүй, гадаргын хувьд үндсэндээ нэгэн хэвийн буюу уулс хоорондын том, жижиг хотгор, хотос бүхий намхан бэсрэг уул, толгодтой юм. Эдгээр хүчин зүйлүүдээс хамааран газрын доорх усны байрлал, усан сүлжээ, тэжээгдлийн нөхцөл, химийн найрлага, тэдгээрийн тоо хэмжээ нь янз бүр байна.

2.5.5. Хөрсөн бүрхэвч

Монгол орны хөрсөн бүрхэвчийн ангиллаар тус талбайн Монгол орны хөрс-газарзүйн мужлалтаар Говийн их мужийн өндрийн бүсшилтэй нутгийн цайвар хүрэн хөрсний дэд бүсийн Баяндэлгэрийн тойрогт хамаарагдана /Монгол улсын үндэсний атлас, 2009/. Судалгааны талбай нь хуурай хээрээс заримдаг цөлийн бүсэд шилжих шилжилтийн бүсэд орших учраас хөрсөн бүрхэвч нь хүрэн шороон хөрснөөс заримдаг цөлийн хөрс хүртэлх шинж чанарыг агуулдаг.

Судалгааны талбай нь цайвар хүрэн хөрсний тойрогт хамаарах боловч Монгол орны хөрсний ангиллаар заримдаг цөлийн бор хөрстэй нутаг юм. Ийм учраас байгалийн бүсийн онцлог, заримдаг цөлийн бор хөрсний үндсэн шинж судалгааны талбайн хөрсөн бүрхэвчийг тодорхойлно. Академич Д.Доржготовын тодорхойлсноор судалгааны талбай орчмын хөрсний онцлог, байгалийн үндсэн хэв шинж зэргийг тодорхойлсныг энд оруулсан болно. Энэхүү үр дүнг өөрсдийн хээрийн судалгааны үр дүнтэй харьцуулан дүгнэлт гаргасан.

Заримдаг цөлийн бүсийн үндсэн хэвшинжийн хөрс болох говийн бор хөрсний тухай анхны судалгааг Б.Б.Полынов (1930) хийсэн бөгөөд түүнээс хойш олон судлаачид (Андреев, 1935, Беспалов, 1951, Соколовский, 1960, Кокорин, 1968, Умаров, Якунин, 1974, Ногина, Евстифеев, Уфимцева, 1977, Рубцова, 1978 болон бусад) энэ хөрсний талаар өөрсдийн бүтээлд дурьдсан байдаг. Бид энэ хөрсийг анх 1968 онд Нууруудын хөндий, Их Нууруудын хотгороор аялахдаа судалж эхэлснээс хойш хангалттай материал хуримтлуулсан юм.

Заримдаг цөлийн бор хөрс говийн хялгана, говийн хазаар өвс, таана, хөмүүл, баглуур, бударгана голлосон цөлөрхөг хээрийн ба хээржүү цөлийн ургамалшил бүхий цав толгодот тал газар, уулсын хоорондох томоохон хотгор, хөндий хоолойг хамарч улсын бүх нутгийн 12.9%-тай тэнцэх хэмжээний талбайг эзлэн тархах бөгөөд түүний дээрх ургамлын бүрхэц даан ч сийрэг (8-10%-иас 20-25% хүртэл) тул цулгуй нүцгэн газар их байна. Газрын дээрх ургамлын биомассын хэмжээ хуурай жил 0.6-1.3 ц/га, чийгтэй жил 1.8-3.5 ц/га хүрдэг бол газар доорх ургамлын үндэсний масс газрын дээрх хэсгээсээ хуурай жил 120 дахин, чийгтэй жил 50 дахин их байдаг ажээ (Гордеева, 1974; Казанцева, 1986; Даваажамц, 1974). Говийн бор хөрсний гадарга дээрх элс-сайр чулуун хучаас хэдий зузаан биш (0.5-2 см) ч гэсэн хөрсний дулааны горимд тодорхой хэмжээгээр нөлөөлж хөрсний өнгөн хэсгийг хэт халалтаас хамгаалдаг онцлогтой.

2.5.6. Ургамлын орчны нөхцөл

Энэ нь нутаг нь Монгол орны ургамал газарзүйн мужлалаар Евразийн хээрийн их мужийн Төв азийн Алтанширээгийн тойрогт хамаарна.

Ургамалжилтын хувьд сөөг, сөөглөг, сөөгөнцөрлөг ургамал дээд дэд, олон наст өвслөг ургамал дунд дээд, нэг наст ургамлын өнгөрсөн жилийн босоо хагд өвст хэвшил тохиолдоно. Талбайн орчим бэлчээр нутаг нь жилийн дөрвөн улиралд ашиглах боломжтой ба ялангуяа намрын бэлчээрт ашиглахад илүү тохиромжтой бэлчээрийн газар. Ургамлын арвийн үнэлгээний хувьд дэд зонхилогч ургамлууд нь *cor1-sp*, бусад зүйл ургамлууд нь *sol* үнэлгээтэй. Ерөнхий тусгаг бүрхэцийн ихэнх хувийг олон наст өвслөг болон сөөглөг, сөөгөнцөрлөг ургамлууд бүрдүүлж, тэдгээрийн 2-р ташингыг олон наст ургамлын хагд ба борог өвс бүрдүүлж байна.

3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчин бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах үндсэн зорилготой.

Тус төслийн БОННУ-д тусгасан Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй төслийн үйл ажиллагаатай холбогдох байгаль орчныг хамгаалах хууль, эрхзүйн орчин, төслийг хэрэгжүүлэх явцад зайлшгүй мөрдөж ажиллах хуулийн хориглосон, хязгаарласан зүйл, заалтууд, төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм, журам, стандарт, Монгол Улсын нэгдэн орсон конвенциудын холбогдох шаардлагуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, тэдгээр эрх зүйн баримт бичгүүдийг мөрдлөг болгон ажиллана.

Төслийн үйл ажиллагаанаас үүдэлтэй гэнэтийн осол эрсдэлээс урьдчилан сэргийлж, хүрээлэн буй орчин болоод нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулж болох бүх талын арга хэмжээг авч эрүүл аюулгүй, байгальд ээлтэй технологийг нэвтрүүлж ажиллана. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний хүрээнд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг боловсруулахдаа сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах чиглэлээр тайланд тусгасан зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээг бүрэн хамарсан.

Тус төлөвлөгөө нь тухайн төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны орон зай, цаг хугацааг бүрэн хамарсан байхаас гадна байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, нөхөн сэргээлтийн арга хэмжээ зэрэг төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө зардал, хариуцан гүйцэтгэх эзэн, хэрэгжүүлэх хугацаа ба давтамжийг бодитойгоор тооцож тусгасан. Тухайн жилийн БОМТ-ний нийт төсөвт 67.3 сая.төг зарцуулахаар төлөвлөсөн.

4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
Агаарын чанар									
1	Үйлдвэрийн бутлах хэсгээс тоосжилт үүсэх	Салхины хурд ихтэй үед ажиллахгүй арга хэмжээг дотоод журамдаа тусгаж өгөх	Үйлдвэрийн бутлах хэсэг	-	50 000			1 улиралд	
2		Бутлах хэсэгт ажиллаж буй ажилчдыг тоосны хамгаалах маскаар бүрэн хангах		ш	5 000	200	1 000.0	Жилийн турш	
3	Болзошгүй аюул, ослын үед хорт хий ялгарч, агаарын чанарт нөлөөлөх	Тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслүүдэд учирсан гэмтлийг цаг тухай бүрт янзалж, дотоод шаталтын хөдөлгүүрийг засварлаж байх	Төсөлд ашиглагдах тээврийн хэрэгслүүд болон тоног төхөөрөмжүүд	-	Эвдрэл гэмтэл гарсан үед				

**“Хэрлэн Импэкс” ХХК-ний Дорноговь аймгийн Айраг сумын нутагт
хэрэгжиж буй “Жонш баяжуулах үйлдвэр” төслийн 2026 онд
хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

2026

4	Баяжуулах үйлдвэрийн дотоод болон гадаад замд тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс тоосжилт үүсэх	Олон шинэ салаа зам гаргахгүй үүднээс чиглэл заасан болон хурдны хязгаарын тэмдэг тэмдэглэгээ байршуулах	Баяжуулах үйлдвэрийн гадаад болон дотоод зам	ш	20 000	6	120.0	1 2 улиралд	
Гадаргын ба газрын доорх усны нөөц									
1	Унд ахуй болон үйлдвэрийн зориулалтаар усыг их хэмжээгээр ашиглах, усан орчинд сөрөг нөлөө үзүүлэх	Тоолуурын баталгаажуулалтын цаг тухай бүрт нь хийлгэх, тоолуур эвдрэл гэмтэл гарсан тухай бүр солих	Баяжуулах үйлдвэрийн гүний худаг	ш	500.0	-	-	Эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд	
2		Худгийн тоолуурын мэдээг сар бүр сумын БОАХМ-ээр батлуулах	Төслийн худгууд	-	Сар бүр тоолуурын заалтыг сумын БОАХМ-ээр баталгаажуулах			Сар бүр	
3	Усан орчинд үзүүлэх нөлөөлөл ямар байгааг	Усан орчны хяналт шинжилгээг тогтмол хийх	Төслийн нийт талбайн хэмжээнд	ш	60 000	4	240.0	2 3 4 улиралд	

**“Хэрлэн Импэкс” ХХК-ний Дорноговь аймгийн Айраг сумын нутагт
хэрэгжиж буй “Жонш баяжуулах үйлдвэр” төслийн 2026 онд
хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

2026

		Үйлдвэрлэлийн аль ч үе шатанд цэвэрлээгүй бохир усыг байгаль орчинд хаяхгүй байх арга хэмжээг зохион байгуулж ажиллах		-	ҮАЗ	Тогтмол	
Хөрсөн бүрхэвч							
1	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнтэй холбоотой үүсэх сөрөг нөлөөлөл	Тээврийн хэрэгслийн шатах тослох материалаар цэнэглэх засвар үйлчилгээ хийх талбайг тусгайлан засаж тохижуулах	Үйлдвэрийн засварын цэг	төг	2 000.0	2 улиралд	Хөрс хамгаалах, цөлжилттэй тэмцэх тухай хууль,
2	Үйлдвэр орчмын хөрс үйлдвэрийн болон ажилчдыг хөдөлгөөний улмаас бохирдож болзошгүй	Хөрсөнд шатах тослох материал алдагдахаас сэргийлж гэмтэл, эвдрэлтэй машин техникийг ажлын талбайд гаргахгүй байх	Эвдрэлтэй машин техник	-	--	Жилийн турш	
3		Ажилчид, суурин дахь захиргаа-үйлчилгээний ажилчдын зорчих явган хүний зам, талбайг зориулалтын хайрган хучилттай болгох	Захиргаа кемпийн хоорондын явган хүний зам	төг	1 000.0	2 улиралд	
4	Хөрсөн орчинд үзүүлэх нөлөөлөл ямар байгааг хянаж,	Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг мэргэжлийн байгууллагаар хийлэгх	Төслийн нийт талбайн хэмжээнд	төг	15 000.0	1 улиралд	

**“Хэрлэн Импэкс” ХХК-ний Дорноговь аймгийн Айраг сумын нутагт
хэрэгжиж буй “Жонш баяжуулах үйлдвэр” төслийн 2026 онд
хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

2026

5		Үйлдвэрийн үйл ажиллагаанд ашиглаж буй химийн бодис, ашигласан тос малын хадгалалт, ашиглалтанд хяналт тавих	Химийн бодис болон ашигласан тос масло хадгалах цэг	-	-	Жилийн турш	
НИЙТ					19,860.0 мян.төг		

5. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ									
№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Ахуйн	Хог хаягдлын цэгийн шинэчлэн байгуулах	Төслөөс үүсч буй бүх хог хаягдал	төг	-	-	5,000.0	1-2 улиралд	Хог хаягдлын тухай хууль “Хог хаягдлын улсын мэдээллийн нэгдсэн сангийн журам”
2		Ахуйн хог хаягдлыг Айраг сумын хогийн цэгрүү тээвэрлэж буй хогийг бүртгэх	Ахуйн хог хаягдал	кг	Бүртгэл хөтлөх			Жилийн турш	
2		Ахуйн хэрэглээнээс гарах хог хаягдлыг зайлуулах гэрээг Айраг сумын ЗДТГ-тай байгуулах	Төслөөс үүсч буй ахуйн хог хаягдал	төг	-		6 000.0	1 улиралд	
3		Ажилчдын кемпээс гарч буй хуванцар савыг цуглуулж, дахин боловсруулах ААН нийлүүлэх	Ажилчдаас үүсч буй хуванцар сав	ш	150.0			Жилийн турш	
4	Үйлдвэрийн	Хуримтлуулсан хог хаягдлыг дахин боловсруулдаг болон устгадаг байгууллагад нийлүүлэх	Хаягдал дугуй, төмөр	10 000.0				Жилийн турш	
5	Аюултай	Ашигласан тос маслыг мэргэжлийн байгуулгатай гэрээ хийж зайлуулах	Төслөөс үүсэх ашигласан тос масло	төг	Гэрээний дүнгээр			Жилийн турш	Аюултай хог хаягдлын журам

**“Хэрлэн Импэкс” ХХК-ний Дорноговь аймгийн Айраг сумын нутагт
хэрэгжиж буй “Жонш баяжуулах үйлдвэр” төслийн 2026 онд
хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

2026

6		Химийн бодисын шингэн үлдэгдэл болон сав баглаа боодлыг мэргэжлийн байгуулгатай гэрээ хийж зайлуулах	Төслөөс үүсч буй химийн бодисын шингэн үлдэгдэл болон шуудай	төг	4 000.0		Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль
Нийт				15,000.0 мян.төг			

6. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	3	4	5	6	7	8
1	Айраг сумын хуучин хогийн цэгийг булшлах	төг			13,000,000	2026	
Нийт			13,000.0 мян.төг				

7. НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Ногоон байгууламжийн төлөвлөгөө	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	3	4	5	6	7	8
1	Мод тарих	төг	300	5 000	1,500,000.0	2026	
2	Баяжуулах үйлдвэрийн кемп орчимын тариалсан модны усалгаа арчилгаа	төг	-	-	500,000	2026	
Нийт			2,000.0 мян.төг				

8. ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
Үйлдвэрийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр								
1	Ослын улмаас хүний эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлж үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох, зогсох,	Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм журмыг сахиулж, хэрэгжилтэд хяналт тавих	Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа	ХАБЭА төсөв			Тогтмол	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль Уурхай, уулын үйлдвэрийн аюулгүй ажиллагааны дүрэм Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулах
2		Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны сургалтыг тогтмол хугацаанд гүйцэтгэх	Баяжуулах үйлдвэрийн ажилчид	ХАБЭА төсөв			ХАБЭА-н төлөвлөгөө	
3		Ажиллагсдын хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах		50		5 000.0	Жилд 2 удаа	

**“Хэрлэн Импэкс” ХХК-ний Дорноговь аймгийн Айраг сумын нутагт
хэрэгжиж буй “Жонш баяжуулах үйлдвэр” төслийн 2026 онд
хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

2026

4		Ажилчдад ослын үед цаг алдалгүй анхны тусламж үзүүлэх зорилготой анхны тусламж үзүүлэх эмийн сан байрлуулж тогтмол дүүргэж байх	Кемп болон баяжуулах үйлдвэр	3	100 000	300.0	Тогтмол	журам MNS ISO 13688 Хамгаалах хувцас – Ерөнхий шаардлага
Байгалийн гамшигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр								
5	Гал түймрийн улмаас үйл ажиллагаа доголдох, зогсох	Гал унтраах багаж хэрэгсэл хүрэлцээтэй хэмжээгээр байрлуулах, галын хорны даралт, бүрэн бүтэн байдлыг тогтмол хянах	-	-			Тогтмол	MNS 5566 Гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн стандарт
6		Гал түймрийн үед хэрхэн ажиллах талаар ажилчдын дунд сургалт явуулах	Нийт ажилчдад	-	-	300.0	Гал түймрийн үед хэрхэн ажиллах талаар ажиллагсд	Барилга байгууламжийн галын аюулгүй байдлын дүрэм Галын аюулгүй байдлын тухай хууль
7		АҮХТ-г батлуулах, төлөвлөгөөний дагуу ажиллах	АҮХТ	-		100.0	ын дунд жил бүр 1 удаа	
8		Гал унтраагуурын хэвийн ажиллагааг хянах	Үйлдвэр орчим	-		150.0	сургалт явуулна.	
Баяжуулах үйлдвэрт осол эрсдэл үүссэн тохиолдолд авах арга хэмжээ								
9	Осол эрсдэл	Баяжуулах үйлдвэрийн бүсэд	Үйлдвэр	ХАБЭА төлөвлөгөөний дагуу			Осол	MNS 4990:2000

**“Хэрлэн Импэкс” ХХК-ний Дорноговь аймгийн Айраг сумын нутагт
хэрэгжиж буй “Жонш баяжуулах үйлдвэр” төслийн 2026 онд
хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

2026

	үүссэн тохиолдолд хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж,	осол гаргах үед удирдлагад мэдэгдэх, ослын түвшинг тогтоож аюулын зэргээс хамаарч түргэн шуурхай арга хэмжээ авах	орчим		эрсдэл үүсэх үед	MNS 4969:2000 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 15-р зүйл
10	үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох, зогсох	Анхны тусламжийн цаг алдалгүй үзүүлж, шаардлагатай тохиолдолд түргэн тусламж, сумын эмнэлэгт хүргүүлэх	Нийт ажилчид	ХАБЭА төлөвлөгөөний дагуу	Осол эрсдэл үүсэх үед	
11	Баяжуулах үйлдвэрт химийн бодис асгарах	Химийн бодис алдагдсан тохиолдолд цааш тархахаас сэргийлж шингээгч материалд шингээн авч, бохирдсон хөрсийг авч тусгай цэгт цуглуулах	Үйлдвэр орчим	ХАБЭА төлөвлөгөөний дагуу	Осол эрсдэл үүсэх үед	
12	Гал түймэр гарсан үед	Гал түймрийн үед баяжуулах үйлдвэрийн аврах бүлгийг цуглуулж АҮХТ дагуу шуурхай арга хэмжээ авах	Үйлдвэр орчим	ХАБЭА төлөвлөгөөний дагуу	Осол эрсдэл үүсэх үед	
Нийт				1,640.0 мян.төг		

9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

№	Байгаль орчны хүчин зүйл	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
		1	2	3	4	5	6	7	8
1	Агаарын сорьц шинжилгээ	NO2 S02	Кемп Баяжуулах үйлдвэр Хаягдлын далан	Жилд 2 удаа	3 цэгт 2 удаа	25.0	150.0	Уурхайн үйл ажиллагаа хэвийн явж байх үед дээжлэлт хийнэ	Дээжлэхдээ MNS 4585:2007, MNS:3384:1982 MNS:4048:1988–г баримтлах
2		Тоос (нийт, PM10, PM2.5)	Кемп Баяжуулах үйлдвэр Бутлуур Хаягдлын сан		4 цэгт 2 удаа	10.0	80.0		
	Хөрсний шинжилгээ	Хөрсний агрохимийн шинжилгээ Чийг, ялзмагийн агууламж: pH, NH4, NO3, SO4, P2O5	Баяжуулах үйлдвэр Харьцуулах хөрс Кемп	Жилд 2 удаа	3 цэгт 2 удаа	25.0	150.0		MNS3298-90 Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлага

**“Хэрлэн Импэкс” ХХК-ний Дорноговь аймгийн Айраг сумын нутагт
хэрэгжиж буй “Жонш баяжуулах үйлдвэр” төслийн 2026 онд
хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

2026

		Хөрсөнд агуулагдах хүнд металлын агууламж: Ni, Cd, Pb, Cu, Zn, Cr	Кемп ШТС Засварын төв Хог хаягдлын цэг Баяжуулах үйлдвэр Хаягдлын далан Хүдэр жигдрүүлэх талбай		7 цэгт 2 удаа	35.0	490.0		MNS5850:2008 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
	Усны шинжилгээ	Усны химийн шинжилгээ	Гүний худгаас Шүүлтүүртэй ундны ус	2 3 4 улиралд	2 цэгт 6 удаа	40.0	320.0		MNS (ISO) 5667-5:2001- усны чанар-дээжлэлт
		Бохир ус: рН, Ж/б, XXX, БХХ, NH ₄ , NO ₂ , NO ₃ , N-нийт, Р-эрд	Ахуйн бохир ус Хаягдлын сангийн ус	Жилд 2 удаа	2 цэгт 2 удаа	65.0	130.0		MNS (ISO) 5667-10:2001 “Усны чанар.дээж авах. 10-р бүлэг. Хаягдал уснаас дээж авах заавар”
		Дуу шуугиан	Тайван байх үед Тоног төхөөрөмж ажиллаж байх үед Тээврийн зам дагуу	Жилд 1 удаа	3 цэгт 1 удаа	30.0	90.0		
	Ургамлын зүйлийн бүрэлдэхүүн	Ургамлын мониторинг	Үйлдвэрийн ургамлыг тодорхойлох 1 цэгт Тээврийн зам дагуу	Жилд 1 удаа	100.0				

Нийт				1,331.3 мян.төг			
10. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ							
№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2026 он				
			Сар 1-3	Сар 4-7	Сар 8-12		
	1	2	3	4	5	6	7
1	Байгаль орчны аудитыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх	14 500.0		X		БО мэргэжилэн	
2	Ажилчдыг гэнтийн ослын даатгалд хамруулах	500.0	X			Хүний нөөцийн мэргэжилтэн	
3	Төлөвлөгөөт газрын хянан баталгаа хийлгэх	5 000.0	X			БО мэргэжилтэн	
	Нийт	14,000.0					
11. БОМТ-НИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ							
№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, мян.төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	
	1	2	3	4	5	6	
2	Засаг дарга, сумын байгаль орчны байцаагч	Бичгэн тайлан	БОМТ биелэлт	2026.11.1-15	500.0	БО мэргэжилтэн	
3	Төрийн захиргааны төв байгууллага	Цахим	БОМТ биелэлт	2026.11.1		БО мэргэжилтэн	
	Нийт				500.0		

12. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСВИЙН
ЗАДАРГАА

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний задаргаа	Зардал
1	Сөрөг нөлөөллийн буруулах арга хэмжээ	19,860,000
2	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	15,000,000
3	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1,640,000
4	Ногоон байгууламжийн төлөвлөгөө	2,000,000
5	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	13,000,000
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1,331,300
7	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	14,000,000
8	Аймаг, сумын орон нутгийн төрийн захиргааны байгууллагын шаардлагаар хийсэн ажил болон нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	500,000
Нийт		67,331,300 төг